MMINFO.
19 дэх жилдээ
# МОНГОЛЫН МЭДЭЭ
Хүн ам 3,160.942... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр
2017.08.30. Лхагва. №144 (4758)
ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ
Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +22
Шөнө +9

УЛС ТӨР
Р.ГАНБАТ: ОЙГ ЦЭВЭРЛЭСНЭЭР ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛЖ, ХӨНӨӨЛТ ШАВЬЖААС СЭРГИЙЛДЭГ
II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС
"БАГШ НАР ЦАЛИНГАА 1.6 САЯ ТӨГРӨГ БОЛГОХ БОЛОМЖ ХЯЗГААРЛАГДМАЛ"
V нүүрт

Дугаарын 60 мөр

## Замын түгжрэлийг бууруулах гээд байна уу, эсвэл..

Н.ПУНЦАГБОЛД

Улаанбаатар хотын хүн ам өсөн нэмэгдэхийн хэрээр ачаалал нь хэтэрч, утаа нь ихэсч, замын түгжрэл нь улам нэмэгдсээр байгаа. Тиймдээ ч Улаанбаатар хотын удирдлагууд замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх, түгжрэлийг сааруулах талаас нь янз бүрийн арга авч байгаа. Дугаараар нь хязгаарлаж эхэлсэн. Хотын авто замуудыг өргөтгөж, шинэчилж, уулзваруудыг өөрчилсөн. Үр дүнгээ өгсөөр байгаа. Гэхдээ автомашины тоо хасагдахгүй нэмэгдэж байгаа болохоор түгжрэл саарахаас илүүтэй ихэсч байна. Тэгвэл сүүлийн үед түгжрэлтэй холбоотойгоор хийж байгаа ажлууд байгаа яг оножу чадаж байна уу гэдэг нь эргэлзээтэй.

Төгсгөл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

## АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүдийг томилжээ

Ерөнхийлөгч Х.Баттулга захирамж гаргаж, АТГ-ын дэргэдэх орон тооны бус Олон нийтийн зөвлөлийн гишүүдийг томиллоо. АТГ-ын дэргэд авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус олон нийтийн зөвлөл 15 хүний бүрэлдэхүүнтэй, дөрвөн жилийн бүрэн эрхтэйгээр ажилладаг бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн захирамжаар байгуулагддаг юм. Ерөнхийлөгчийн захирамжийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд уншин танилцуулж, АТГ-ын дэд дарга Ц.Нямдоржид гардуулан өгөв. Монгол Улсын Ерөнхийлөгчийн захирамжаар Авлигатай тэмцэх газрын дэргэдэх орон тооны бус Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах хүмүүсийг гишүүнээр томилжээ. Тухайлбал, "Легитимус" ТББ-ын хуулийн зөвлөх, хуульч Б.Анхныбаяр, Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Г.Баасан, "Шинэ Улаанбаатар" ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Э.Батсуурь, Улс төр боловсролын академийн Удирдах зөвлөлийн гишүүн Р.Бурмаа зэрэг 15 хүнийг томилсон байна. Үүний дараа Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл анхны хурлаа хийж Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Г.Баасанг даргаараа томиллоо.

АМЖИЛТЫН ЭЗЭД

# Г.Болдбаатар, М.Уранцэцэг нар ДЭЛХИЙН ХОС МЕДАЛЬТАН БОЛЛОО





Н.БОЛД

Унгарын нийслэл Будапешт хотноо жүдо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн өнгөрсөн даваа гарагт эхэллээ. Энэ удаагийн дэлхийн аваргад 126 орны эрэгтэй 440, эмэгтэй 291, нийт 731 тамирчин өрсөлдөж байна. Харин манай улсаас эрэгтэй, эмэгтэй тус бүр ес, нийт 18 тамирчин оролцож байгаа билээ. Эрэгтэйчүүдээс 60 кг-д Г.Болдбаатар, Д.Амартүвшин, +100-д Н.Түвшинбаяр, Ө.Дүүрэнбаяр нар зодоглож байна. Харин эмэгтэйчүүдийн 52, 57, 63 кг-д хоёр бөх сойж байгаа. -78 кг-д энэ удаад бөх илгээгээгүй. Тэгвэл эхний өдөр л манай баг тамирчид нэг мөнгө, нэг хүрэл медаль хүртэж, гараагаа тун амжилттай эхлүүллээ. Даваа гарагт эрэгтэйчүүдийн 60, эмэгтэй 48 кг-ын жингийн барилдаан болсон. Манайхаас 60 кг-д дэлхийн аварга Г.Болдбаатар, дэлхийн аваргын мөнгөн медальт Д.Амартүвшин нар зодоглосон. Харин 48 кг-д дэлхийн аварга М.Уранцэцэг барилдсан юм. Манай шилдэг гурван бөхөөс М.Уранцэцэг мөнгө, Г.Болдбаатар хүрэл медаль хүртлээ. М.Уранцэцэг аваргын хувьд эхний тойрогтоо хийлж, хоёрдугаар тойрогт Румыны Александра Попыг ялсан.

Үргэлжлэл нь VIII нүүрт

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

# ОХУ, МОНГОЛЫН ТӨРИЙН ТЭРГҮҮНҮҮД ВЛАДИВОСТОКТ УУЛЗАХААР ТОХИРОЛЦЛОО



Б.ДАВААХҮҮ

"Монголын мэдээ" сонин хоёр хөршийн болоод дэлхийн томоохон хэвлэл Монгол Улсын талаар хэрхэн мэдээлж буйг "Монгол дэлхийн хэвлэлд" булангаараа орчуулан хүргэдэг билээ. Энэ удаад Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин нарын Унгарын Будапешт хотод болсон уулзалтын талаар Оросын ТАСС агентлаг хэрхэн мэдээлснийг орчуулан хүргэж байна. Мөн "Синхуа", "Ройтерс" агентлагт Монголын улс төрийн өнөөгийн нөхцөл байдлын талаар хэрхэн нийтэлснийг уншигчиддаа сонирхуулахаар бэлтгэлээ.

Төгсгөл нь III нүүрт




| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2435.00 | 2452.00 | ФУНТ | 3117.00 | 3199.00 |
| ЕВРО | 2835.00 | 2900.00 | РУБЛЬ | 39.70 | 41.60 |
| ИЕН | 22.17 | 22.69 | ЮАНЬ | 363.50 | 367.40 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2428.00 | 2444.00 | ФУНТ | 3056.00 | 3178.00 |
| ЕВРО | 2825.00 | 2926.00 | РУБЛЬ | 39.69 | 43.32 |
| ИЕН | 21.70 | 22.68 | ЮАНЬ | 364.00 | 367.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

## МАН бүлэг ээлжит бусаар хуралдлаа

УИХ дахь МАН болон АН-ын бүлэг өчигдөр Төрийн ордонд хуралдлаа. МАН-ын бүлгийн хуралдаан 14:00 цагт эхлэх байсан хэдий ч гишүүдийн ирц хүрэлгүй хүлээгдсээр товлосон хугацаанаас цагийн дараа эхэлсэн юм. Хуралдаанд нийт 40 гаруй гишүүн оролцсон бөгөөд УИХ-ын дарга М.Энхболд, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Шадар сайд У.Хүрэлсүх, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нар оролцлоо. Уг хурлаар Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг огцруулах МАН-ын 30 гишүүний санал, Шадар сайд У.Хүрэлсүхийн албанаас чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцэв. Мөн санал гаргасан гишүүдийг бүлгийн хуралдаанд оролцохгүй гэх мэдээлэл гарсан ч тэд хуралдаандаа оролцсон юм. Энэ удаагийн бүлгийн хуралдаанд МАН ихээхэн ач холбогдол өгсөн бөгөөд хурал болж буй хэсэгт сэтгүүлчдийг явуулахыг хориглов. Тодруулбал, Төрийн ордоны баруун жигүүрт МАН-ын бүлгийн хуралдаан болсон. Тус хэсэгт харуул хамгаалалт гарган хэвлэл мэдээллийн ажилтнуудыг нэвтрүүлэхийг хориглосон байна.

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

# Р.Ганбат:

Б.ЗАЯА

*Ойн мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид болон албаны хүмүүс ойн санг цэвэрлэх зайлшгүй шаардлагатай хэмээн ярьдаг. Тэгвэл энэ асуудлаар БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Р.Ганбаттай цөөн хором ярилцав.*



# ОЙГ ЦЭВЭРЛЭСНЭЭР ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛЖ, ХӨНӨӨЛТ ШАВЬЖААС СЭРГИЙЛДЭГ

**-Дараалсан олон удаагийн түймэр болон бусад хүчин зүйлээс шалтгаалж ой модыг цэвэрлэх шаардлагатай гэж мэргэжлийн хүмүүс ярьдаг. Үнэхээр шаардлага байгаа юу, байгаа бол Монгол орны хэдий хэмжээний ойн санг цэвэрлэх шаардлагатай байгаа вэ?**

-Байгаль, цаг уурын нөлөө, хүний хүчин зүйл, дэлхийн дулаарал зэргээс шалтгаалсан гал түймэр ойн санд ихээхэн аюул учруулж байна. Түүнээс гадна ойн хортон шавьж, хууль бус мод бэлтгэл нь ойг хомсдуулдаг гол хүчин зүйл болдог. БОАЖЯ-ны харьяа Ойн судалгаа, хөгжлийн төв гэж байгууллага байдаг. Тус байгууллагаас гаргасан судалгаагаар Монгол Улсын хэмжээнд 2.7 сая га талбайд, 69.8 сая шоо метр унасан болон хатсан модны нөөц байна. Үүний 39.9 сая шоо метр нь хатсан буюу ургах чадваргүй болсон мод. Үлдсэн нь унасан мод байгаа юм. Яагаад ийм их хэмжээний унасан болон хатсан модны нөөц бий болчихов оо гэхээр, гол хүчин зүйл нь гал түймэр, ойн хөнөөлт шавжийн нөлөөгөөр. Тэгэхээр түймрийн хор хохирол ойн төлөв байдлыг ямар хэмжээнд хүртэл нь доройтуулдаг, хомсдуулдаг нь энэхүү тоо баримтаас харагдаж байгаа биз. Дээрээс нь хатсан, унасан мод нь гал түймэр гарахад шатах материалын нөөц болж дэмжиж өгдөг. Энэ нь ойн санд учрах аюулыг улам нэмэгдүүлдэг. Эдгээрээс харахад, ой модыг зайлшгүй цэвэрлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

**-Ойг цэвэрлэсний ач холбогдлыг тодорхой тайлбарлавал?**

-Ач холбогдлын хувьд байгальд болон нийгэм, эдийн засагт гэж хоёр ангилж болно. Байгаль экологид ямар ач холбогдолтой гэхээр, хэвийн байсан ой шатсаны дараа төлөв байдал нь өөрчлөгддөг. Ургах орчин, газрын гадарга дахь өвс, ургамал нь солигдох гэх мэт. Ингэснээр ой нөхөн төлжих процесс нь алдагдаж эхэлдэг. Харин ойг цэвэрлэснээр ойн түймрийн эрсдлийг бууруулж, иш холтос, модлогийн шавжийн хөнөөлөөс урьдчилан сэргийлэн, нөхөн төлжих үйл явцыг нь хангаж өгнө гэсэн үг. Нөгөө талдаа цэвэрлэгээнээс гарсан модоор ард иргэд, аж ахуйн нэгжийн модны хэрэгцээг хангаж болно. Ойн нөөц ашигласны төлбөр гэж байдаг. Түүнийгээ тухайн орон нутгийнхаа төсөвт өгснөөр төсөв бүрдүүлэлт сайжирна. Аж ахуйн нэгжийн орлого нэмэгдэнэ. Гэх мэтчилэн эдийн засгийн ач холбогдол их. Ойг цэвэрлэснээр ямар үр дүн гардаг, ямар ач холбогдолтой вэ гэдгийг тодорхойлсон судалгааны материал байдаг. Жишээлбэл, ойг цэвэрлэснээр ойн түймрийн эрсдлийг хоёр дахин, ойн түймэрт өртөх талбайн хэмжээг 3-4 дахин бууруулдаг. Ойн модны түймэрт тэсвэрлэх чадварыг хоёр дахин нэмэгдүүлнэ. Нөгөө талаар, модны иш, холтос, үндсээр хооллогч хортон шавьжны хэт олширлыг багасгадаг. Мөн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжийг байнгын ногоон ажлын байр бий болно. Ойн цэвэрлэгээнээс гарсан модыг дан ганц ахуйн хэрэгцээнд зарцуулдаггүй. Ойн цэвэрлэгээнээс гарсан модоор янз бүрийн бордоо, барилгын материал, хавтан зэргийг үйлдвэрлэж болдог олон талын ач холбогдолтой.

**-Ойг цэвэрлэхэд ямар хүндрэл учирдаг талаар яривал?**

-Цэвэрлэх ёстой ой маань төв суурин газар эсвэл дэд бүтцээсээ алслагдсан байдаг. 70, 80 км түүнээс цааш зайтай байна. Намаг, шавар ихтэй. Хүн хүрэхэд хамгийн хэцүү газруудад унасан, хатсан модны нөөц илүү их байдаг. Энд юу гэж хэлэх гэж байна вэ гэвэл ойн замын асуудлыг бодлогын хүрээнд, хөрөнгө, зардлын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байгаа юм. Түүнээс гадна ойн цэвэрлэгээ хийх аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн чадавхи муу байдаг. Техник технологийн асуудлыг мөн нэрлэж болно. Гэх мэт хүндрэлүүд бий.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Б.Бат-Эрдэнэ: Бид бүх төвшинд хариуцлага хүлээнэ



Ховд аймагт цэргийн алба хааж байсан албан хаагчид голд живж, амь насаа алдсан хэрэг гарсан билээ. Амиа алдсан гурван цэргийн цогцсыг эрэн хайх ажиллагаа үргэлжилж байгаа юм. Тэгвэл энэ асуудлаар Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр "Батлан хамгаалах салбарт хариуцлага суларсан гэдэгтээ санал нэг байна. Энэ асуудлыг би УИХ-ын чуулганы хаалттай хуралдаанд мэдээлэл өгч, тодорхой асуудлыг гаргаж тавьж байсан.

Тиймээс энэ салбарт ажил авсан цагаас хойш ямар нэг асуудлыг нуухгүйгээр иргэний хяналтыг тавих үүргийн хүрээнд гаргаж байгаа. ЗХЖШ-д ч ийм шаардлага тавьж байгаа. Цэргийн албан хаагчид голд осолдсон асуудлаар нарийн мэдээлэл одоогоор ирээгүй байна. Би хариуцлагаа хүлээнэ. Бид бүх төвшинд хариуцлагаа хүлээнэ. Цэргийн мэргэжлийн удирдлагыг ЗХЖШ, түүний дарга хэрэгжүүлдэг. Хуулиар ЗХЖШ-ын дарга зэвсэгт хүчин, цэрэг, түүний сахилга, бэлэн байдал, осол, аюулгүй байдлыг хариуцдаг. Тиймээс шат шатандаа хариуцлага яригдана. Албаны ажлын хэсгийн дүгнэлт гарсны дараа энэ асуудал яригдана" хэмээн ярьжээ.

## Монгол Улсын эдийн засаг 5.3 хувиар өссөн гэв

АНУ-ын Элчин сайдын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан Монгол дахь Америкийн худалдааны танхимын наймдугаар сарын уулзалт өчигдөр боллоо. Уг уулзалтад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дарга Ж.Мөнхбат оролцсон юм. Энэ үеэр тэрбээр "Өнгөрсөн онд хасах хувьтай байсан эдийн засаг 5.3 хувиар өсч, он гарснаас хойш төсвийн орлого тогтмол давж биелж байгаа нь Засгийн газраас явуулж байгаа бодлого, үйл ажиллагаа, ОУВС, бусад байгууллага, улс оронтой хамтарч ажиллаж байгаагийн үр дүн" хэмээн онцоллоо. Уулзалтад оролцсон хөрөнгө оруулагчид Монгол Улсын төр, засаг нь тогтворгүй, хууль, дүрэм, журмаа байнга өөрчилдөг нь эргэлзээ төрүүлдэг, төрийн байгууллага, албан тушаалтнууд хүнд сурталтай, дарамт, шахалт үзүүлдэг талаар санал хэлж байв. Мөн татварын бодлогоор хөрөнгө оруулагчдыг хэрхэн дэмжих, томоохон төсөл, хөтөлбөрийн дэд бүтцэд анхаарах, шинээр хөрөнгө оруулалт татах чиглэлээр төлөвлөсөн ажлын талаар тодруулсан юм. Мөн Засгийн газрын дэргэдэх Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг илүү тогтвортой, таатай болгох үүднээс "Хөрөнгө оруулагчаас төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх журам"-ын төсөл боловсруулсан. Мөн хуулиудын зөрчил, давхардал, хийдлийг арилгах зорилготой хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар бэлтгэж байна.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

# ИРЭЭДҮЙН ЭРЧИМ ХҮЧИЙГ АСТАНАД ТАНИЛЦУУЛЛАА

Х.ОЧ

Ирээдүйн эрчим хүч уриатай олон улсын Экспо-2017 үзэсгэлэн зургадугаар сарын 10-аас Казахстан улсын нийслэл Астана хотод нээлтээ хийсэн бөгөөд есдүгээр сарын 10 хүртэл үргэлжлэх ажээ. Дэлхий даяар эрчим хүчний өөр эх булаг хайх асуудал чухал болж байгааг судлаачид санал нэгтэй баталж байна. Үзэсгэлэнгийн үеэр эрдэмтэн судлаачид эрчим хүчийг далайн гүний урсгал, далайн усны давалгаа, болон сансрын шороон шуурганаас гаргаж болох талаар танилцуулжээ. Орчин үед атомын цахилгаан станц гаргаж буй эрчим хүчийг 10м х 10м талбай бүхий нарны цахилгаан үүсгүүрээс гаргаж чадахуйц технологи бий болжээ.

Энэ удаагийн экспод 115 орон оролцож байгаа бөгөөд улс орон бүр эрчим хүчний шинэ технологийг танилцуулж байв. БНСУ нарны цахилгаан үүсгүүрээр ажилладаг нисэх онгоцыг танилцуулж, өөрийн улсынхаа ирээдүйн технологийн дэвшил ямар хэмжээнд байгаагаа харуулсан юм. Тэдний хэлж байгаагаар ухаалаг технологиуд удахгүй хүн болгонд хүртээмжтэй болж үйлчлэх ажээ. Харин манай урд хөрш нисдэг галт тэргийг бүтээж оролцлоо. Хятадууд нарны эрчим хүч нь мөнхийн эрчим хүчний эх үүвэр мөн гэдгийг харуулж чаджээ. Японччууд айл гэрийн ахуйн нөхцөлд ухаалаг эрчим хүчний хэрэглээ байдгийг үзүүлжээ. Тэд хөргөгч, индүүнээс бусад нь эрчим хүч гаргаж болохыг олон нийтэд танилцуулав. Эдгээр азийн орнуудын үзэсгэлэнгийн павильонд хамгийн олон үзэгч цугларч байлаа. Европчуудын хувьд гэвэл, Итали далай тэнгисийн усны түрлэг, ойлтоос гаргасан эрчим хүчний ашиглалт хэрэглээг танилцуулав. Энэ нь тэдний гол технологи байв. Герман амьд ногоон замгаар тавцан хийсэн байшин үзүүлэв. "Ухаалаг байшин" гэсэн дээрх технологи хэрхэн эрчим хүч хэмнэх боломжтойг харуулжээ. Тусгай түлхүүрийн тусламжтайгаар өөрсдөө эрчим хүчний эх үүсвэр болж болох ажээ. Германы эрдэмтэд цахилгаанаар ажилладаг спорт, уралдааны машин авчирсан байв. Ийм байдлаар ЭКСПО-ийн павильон бүхнээс шинэ технологи, орон орны ирээдүйн эрчим хүчний дэвшилтэт хэрэглээний талаар тодорхой мэдээлэл олж авах боломжтой байлаа. Словакуудын бүтээл сонирхол татаж байв. Тэдний танилцуулсан тохилог байшинг дэлхийн хаана ч хэрэглэж болох ажээ. Майхан шиг зөөж авч явахад хялбар юм. Экспо-2017 үзэсгэлэнгийн бас нэг сонирхол татсан хэсэг нь өдөр улс орнууд өөр өөрсдийн үндэсний өдөрлөгийг зохион байгуулсан явдал юм. Зөвхөн үзэсгэлэн төдийгүй олны сонирхлыг татсан шоу тоглолтуудыг зохион байгуулж байв. Оросын павильонд дуу хуур элбэг, үзэгчид олонтой байлаа. Зуны халуун сард сэрүүн орчин бий болгох төхөөрөмжүүдийг байрлуулжээ. Үүгээр оросын Арктик гэсэн технологи, эрчим хүчний шийдлийг харуулж байгаа ажээ. Дэлхийн бөмбөрцгийн бүх усаар "Академич Ломоносов" атомын хөлөг онгоц асар том мөсөн уулыг чирж буй макет тавьжээ. Энэ нь 20 мянган хүн амтай хот суурин гэрлээр хангах чадамжтай юм. Хамгийн том үзэсгэлэнг зохион байгуулагч Казахстан улс танилцуулжээ. "Нур Алем" хэмээн нэрлэгдсэн найман давхар бүхий павильонд Казахстан улс эрчим хүчний шинэ эх үүсгэврийн бүх боломжийг дэлгэж үзүүлсэн байна. Зохион байгуулагчид шинжлэх ухааны ололт үр дүнг олон үзүүлбэртэй хослуулж сонирхолтой болгож чадсан байлаа. Казахстан улсад 50 гаруй төсөл хэрэгжиж байгаа бөгөөд бараг 2000 мегаватт чадалтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хэрэгжүүлж байгаа юм. Энэ чиглэлээр төв Азийн хэмжээнд тэргүүлж байгаа гэнэ. Сүүлийн таван жилд Европын холбооны санхүүгийн байгуулагууд Казахстаны "ногоон" эрчим хүчний салбарт 500 сая еврогийн хөрөнгө оруулалт оруулжээ. "Бид Казахстанаас нефть,уран авахыг багасгах сонирхолтой байгаа. Европын холбоо



ураны хэрэглээнийхээ 21 хувийг Казахстанаас авдаг. Бид сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх сонирхолтой байгаа. Үр дүнд хүрсэн төсөл нэлээд байна. Судалгаа хийгдаж буй ажлууд ч олон байгаа. Сүүлийн таван жилд 500 сая еврогийн хөрөнгө оруулалт хийсэн. Өнөөдөр гэхэд Европын холбоо эрчим хүчний ухаалаг шийдэл бүхий байр байшин барихад анхаарлаа хандуулж байна" гэж Европын холбооны эрчим хүчний захирлуудын зөвлөлийн дарга Герасимос Томос Астана ЭКСПО 2017-д үг хэлэхдээ мэдэгдэв.

1878 оны Парисийн "Дэлхийн үзэсгэлэн яармаг"-т Томас Эдисон өөрийн бүтээсэн эгшигт хайрцаг, фонограф танилцуулж байсан бол Александр Белл телефон утасны шинэ загвар харуулж байв. Оросын инженер Яблочков "Цахилгаан лаа" тавьсан байсан нь түүх болон үлджээ. Өдөрт 30 гаруй мянган хүн Астанагийн экспог үзэж байгаа ажээ. Мөн Экспо-2017 үзэсгэлэнгийн үеэр гэрээ хэлэлцээр олноор хийгдэж, хөрөнгө оруулалт яригдаж байв. Олон улсын хэмжээний үзэсгэлэн яармагт бэлтгэх явцад нийслэл Астана хотын өнгө үзэмж үлэмж өөрчлөгдөн сайжирсан байна. Шинэ дэд бүтэц бий болж хуучин бүхэн шинэчлэгдэх боломжтой болжээ. Нисэх буудалд гэхэд л шинэ терминал нээгдэв. Төмөр замын буудал дэлхийн стандартад хүрчээ. Орон сууцны шинэ шинэ хорооллууд баригдаж байна. Өөрөөр хэлбэл Экспо бол Казахстанд хамгийн том бүтээн байгуулалт болсон ажээ. Барилга бүтээн байгуулалт нь хотын эдийн засагт шинэ түлхэц өгсөн юм. Экспо нь хөрөнгө оруулалт нэмэгдүүлж, хотын тээврийн дэд бүтцийг сайжруулах боломж олгосон ба нийгмийн талын олон асуудлыг шийдвэрлэх нөхцлийг тавьж өгсөн ажээ. Үзэсгэлэн яармагт зориулж барьсан барилгыг цаашид ашиглах асуудал ч төлөвлөгджээ. Павильоны байранд "Астана" гэдэг олон улсын санхүүгийн төв үйл ажиллагаа явуулах юм. Энэ барилгын нэг хэсэгт Назарбаев их сургуулийн технопарк байх ажээ.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

# ОХУ, МОНГОЛЫН ТӨРИЙН ТЭРГҮҮНҮҮД Владивостокт уулзахаар тохиролцлоо

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

### ТАСС: Х.Баттулгад В.Путин баяр хүргэлээ

Унгарын нийслэл Будапешт хотноо эхэлсэн Жүдо бөхийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын төрийн тэргүүн В.Путинтай уулзсан. Тэрбээр Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулснаасаа хойш анх удаагаа хойд хөршийн тэргүүнтэй уулзсан нь энэ байсан юм. Тэгвэл тус уулзалтын талаар Оросын “ТАСС” агентлагийн цахим хуудаст “ОХУ, Монголын төрийн тэргүүнүүд Дорнын эдийн засгийн чуулганы үеэр дахин уулзахаар боллоо” гэсэн гарчиг бүхий мэдээлэл нийтлэгджээ.

...Энэ жил нүүрсний үнэ өндөр байгаа нь Монгол Улсын эдийн засгийг хурдацтай өсөхөд хүргэсэн. Гэвч энэ оны эхээр, гадаадын хөрөнгө оруулалт буурч, түүхий эдийн үнэ унасантай холбоотойгоор Монгол Улс Олон улсын валютын сангаас санхүүгийн хямралыг хөнгөвчлөх, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхэд чиглэсэн 5.5 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох хүсэлт гаргасан юм” гэжээ.




Үүнд “ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга нар ирэх сард Владивосток хотноо болох дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын үеэр хоёр талын яриа хэлэлцээр хийхээр тохиролцлоо. Даваа гарагт болсон уулзалтын үеэр В.Путин жүдо бөхийн ДАШТ-д Монголын тамирчид амжилттай оролцож байгаатай холбогдуулан Х.Баттулгад баяр хүргэсэн юм. Тэрбээр “Би тантай биечлэн уулзаж байгаадаа баяртай байна. Бид бүхэн таныг улс төрч бөгөөд сайн тамирчин гэдгээр чинь сайн мэднэ. Монголын жүдочид ДАШТ-д амжилттай оролцож байна. Танд баяр хүргэе” гэв.

Тэрбээр мөн Владивостокт болох эдийн засгийн чуулга уулзалтын үеэр Х.Баттулгатай уулзаж, хоёр улсын харилцааны талаар илүү дэлгэрэнгүй яриа өрнүүлэхээр төлөвлөж буйгаа дуулгажээ. В.Путин ОХУ-Монголын худалдаа энэ онд нэлээд ахицтай байгааг дурьдаад, “Өнгөрсөн онд 20 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан худалдааны эргэлт зөвхөн 2017 оны 1-6 сард 34 хувийн өсөлттэй үзүүлэлттэй байна” гэлээ. Мөн хоёр талын эдийн засаг болон соёлын харилцааг улс төрийн харилцааны адил илүү өндөр түвшинд гаргахад анхаарлаа хандуулахыг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин уриаллаа. Тухайлбал, Орос-Монголын хамтарсан үйлдвэр, компаниудын үйл ажиллагааг идэвхжүүлж, Орос-Монголын хил дамнасан ачаа тээврийн тоо хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй байна гэж В.Путин онцлон тэмдэглэв. Үүний хариуд Х.Баттулга ч жүдо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр В.Путинтай уулзаж буйдаа баяртай байгаагаа илэрхийлэхийн сацуу “Бид хоёрын хэн хэн нь энэ спортыг сонирхдог, энэ спортод хайртай учраас иймэрга хэмжээний үеэр уулзах хувьтай байжээ. Бидний энэ сонирхол цаашдын хамтын ажиллагаанд нөлөөлөх нь дамжиггүй” хэмээлээ.

Мөн тэрбээр В.Путины саналыг дэмжиж, Владивостокт илүү дэлгэрэнгүй яриа хэлэлцээр өрнүүлэхээ илэрхийлэхийн ялдамд, хоёр талын худалдааг өргөжүүлэх бодолтой байгаагаа дурьдлаа. Х.Баттулга “Би одоогийн бодит байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр хойд хөрштэйгөө харилцаагаа улам бүр бэхжүүлэхийг эрмэлзэж байна” гэв.

Тэрбээр цааш нь худалдааны эргэлт өссөн нь хил дамнасан худалдаа өссөнтэй холбоотой гээд, 4000 гаруй км урттай Орос-Монголын хил дамнасан хамтын ажиллагааг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй байгааг уриалсан юм. Түүнчлэн, Х.Баттулга хөрөнгө оруулалтад онцгой анхаарал хандуулахаа мэдэгдэж, Монгол-Оросын хамтарсан “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийг дурьжээ. В.Путин ч түүний саналыг зөвшөөрч буйгаа илэрхийллээ. ОХУ-ын Владивосток хотод ирэх есдүгээр сарын 6, 7-нд дэлхийн эдийн засгийн гуравдугаар чуулга уулзалт зохион байгуулагдах юм.

### Xinhua: Ж.Эрдэнэбатын огцруулах асуудлыг 15 хоногийн дотор шийдвэрлэх учиртай

БНХАУ-ын төрийн мэдлийн “Синхуа” агентлагийн цахим хуудаст Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг огцруулах тухай шаардлагыг эрх баригч намын гишүүд гаргасан тухай мэдээлэл нийтлэгдсэн байна. Тус мэдээллийг эх хэлнээ хөрвүүлбэл, “Монголын эрх баригч МАН-ын 30 гишүүн Ерөнхий сайд Жаргалтулгын Эрдэнэбатыг огцруулахад нэгдэн гарын үсгээ зуржээ. Улмаар огцруулах шаардлагаа УИХ-ын дарга М.Энхболд эзгүй байсан тул УИХ-ын дэд дарга Я.Санжмятавд гардуулан өгсөн байна.

МАН УИХ-д 65 суудалтай. Гэвч, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг концессын гэрээ, хүүхдийн тэтгэмж, уул уурхайн компаниудын хувьцаа гэх мэт эдийн засгийн гол түлхүүр болсон хууль тогтоомжийг зөрчсөн хэмээн тэдгээр гишүүд буруутгаж байгаа юм байна. “Түүний гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа нь хэдхэн бүлэглэлийн эрх ашигт нийцэж байна” гэж УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан хэллээ. Монгол Улсын хуульд зааснаар Ж.Эрдэнэбатыг огцруулах тухай асуудлыг 15 хоногийн дотор хэлэлцэн, шийдвэрлэх учиртай юм. Эдүгээ 44 настай МАН-ын гишүүн Ж.Эрдэнэбат 2016 оны долдугаар сард Ерөнхий сайдаар томилогдсон юм.

Дашрамд дурьдахад, Шадар сайд У.Хүрэлсүх албан тушаалаасаа огцрох хүсэлтээ Эрдэнэбатад хүргүүлсэн удаатай. Тэрбээр огцрох хүсэлтдээ өнөөгийн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын бодлого, үйл ажиллагаа нь үндэсний эрх ашигт нийцэхгүй байгаа тул хамтарч ажиллаж чадахгүй гэдгээ дурьджээ” гэсэн байна.

### Reuters: 2004 оноос хойш нэг ч Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хугацааг дуусгаагүй

ОХУ-ын “Ройтерс” агентлагийн сэтгүүлч Терренс Эдвард манай улсын улс төрийн ертөнцөд үүсээд буй Засгийн газар огцруулах эсэх талаарх дуулиан шуугианы талаар нийтлэл бичжээ. Түүнд “Монголын зарим хууль тогтоогчид Ерөнхийлөгчийн сонгуульд нам нь ялагдал хүлээсэнтэй холбоотойгоор Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг албан тушаалаасаа огцрохыг шаардлаа. Эрх баригч МАН-ын гишүүн Т.Аюурсайхан УИХ-ын 76 гишүүний 30 нь Эрдэнэбатын Засгийн газрыг огцруулахыг дэмжин гарын үсэг зурсан талаар твиттер сүлжээндээ нийтэлжээ. Мөн тус мэдэгдлээ бусад нийгмийн сүлжээнд хуулбарлан нийтэлсэн байв.

Одоогоор Ерөнхий сайдын ажлын албанаас тус огцруулах бичигтэй холбоотойгоор ямар нэг тайлбар хийгээгүй байгаа юм. МАН 2016 оны парламентын сонгуулиар УИХ-ын 76 суудлын 65-д нь ялалт байгуулсан. Гэвч, өнгөрсөн сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтад МАН-аас нэр дэвшсэн УИХ-ын дарга М.Энхболд сөрөг хүчний нэр дэвшигч самбо бөхийн тамирчин асан, бизнесмэн Х.Баттулгад ялагдсан юм. Энэ ялагдал МАН-ын Засгийн газрын хатуу бодлого, авлигын дуулианд ард түмний өгсөн дүн гэж харагдаж буй. Монголын парламентын засаглалын дагуу Ерөнхий сайд Засгийн газрыг тэргүүлэх бол Ерөнхийлөгч хууль санаачлах, хориг тавих зэрэг хязгаарлагдмал эрхтэй байдаг. 1990 онд хуучин Зөвлөлт холбоот улсын хараат байдлаас гарч, ардчилсан тогтолцоонд шилжсэн Монгол улсад Засгийн газар солигдох нь бараг нийтлэг үзэгдэл болж хувираад байна.

Тодруулбал, 2004 оноос хойш нэг ч Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ дөрвөн жилийн хугацааг дуусгаж байгаагүй юм. Энэ жил нүүрсний үнэ өндөр байгаа нь Монгол Улсын эдийн засгийг хурдацтай өсөхөд хүргэсэн. Гэвч энэ оны эхээр, гадаадын хөрөнгө оруулалт буурч, түүхий эдийн үнэ унасантай холбоотойгоор Монгол Улс Олон улсын валютын сангаас санхүүгийн хямралыг хөнгөвчлөх, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхэд чиглэсэн 5.5 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох хүсэлт гаргасан юм” гэжээ.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** Суудлын автомашин худалдан авах
**Тендер шалгаруулалтын дугаар:** НДХААА-2017/Б-14

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос Суудлын автомашин–ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**
**Борлуулалтын хэмжээ:** 2015, 2016 оны дундаж 60.0 сая төгрөгөөс багагүй байна.
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 60.0 сая төгрөгөөс багагүй
**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2015, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
**Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** 2015, 2016 онд 60.0 сая төгрөгөөс багагүй
**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Шаардлагагүй

Тендерийн хамт 640’000 /зургаан зуун дөчин мянган/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 10 дугаар сарын 02–ны өдрийн 10.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 10 дугаар сарын 02–ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: “Тооцохгүй”**
**Дотоодны давуу эрх тооцох эсэх: “Тооцохгүй”**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**НАЛАЙХ ДҮҮРЭГ, 2-Р ХОРОО, ХУУЛЬЧДЫН ГУДАМЖ,**
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА.**
**УТАС:7023-2788**

# ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**2017.08.30**

[Түмэнцогт Ус Дулаан ОНӨҮГ] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [Иж бүрэн халаалтын тогоо]–ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг [2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 10 цаг]-аас өмнө [Түмэнцогт Ус Дулаан ОНӨҮГ-ын байр 2-р давхар, инженер Э.Отгонтөгс, 80990100, нярав О.Болорцэцэг, 97012199] хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан [2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн]-ны өдрийн [10 цаг 30 минутанд] -т нээнэ.

**Дотоодын давуу эрх тооцохгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**[СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ СУМ 3-Р БАГ ТҮМЭНЦОГТ УС ДУЛААН ОНӨҮГ-ЫН БАЙР 2-Р ДАВХАР, ИНЖЕНЕР Э.ОТГОНТӨГС, 80990100, НЯРАВ О.БОЛОРЦЭЦЭГ, 97012199]**


Дугаарын **60** мөр

# Замын түгжрэлийг бууруулах гээд байна уу, эсвэл..

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Зүүн эргүүлэхгүй байх шийдвэр түгжрэлийг улам л нэмж, туслах замуудын ачаалал дээд цэгтээ хүрсэн. Тиймээс шийдвэрээ эргэж харах шиг боллоо, дарга нар. Дээрээс нь “Авто плаза” төвийн уулзвар гээчийг нээлээ. Дөрвөн замын уулзвар маягтай болгосон. Урагшаа “Дашчойлон” хийд рүү аль ч талаасаа эргэж болохоор болж байгаа юм.

Мөн хойшоо 16 дугаар сургууль руу эргэнэ. Энэ уулзварыг нээснээр Их тойруу дахь 100 айл, Өлзий төвүүдийн ачаалал 20-30 хувь буурна гэж албаныхан үзэж байгаа юм билээ. Мэдээж тооцоо, судалгаа хийж байж л уулзвар шинээр барьж, замаа өөрчилж, шинэчилдэг байлгүй дээ. Гэхдээ “Авто плаза” хавьд уулзвар нээснээр замын хөдөлгөөний ачаалаал 20-30 хувь буурна гэдэгтэй санал нэг л нийлэхгүй байна шүү. Өмнө нь энэ замаар аятайхан яваад байж болдог байсан.

Одоо түгжрэл нь улам нэмэгдчихлээ. Уулзвар тэрүүхэн тэндээ л сайхан харагдаж байгаа байх. Урагшаа эргээд “Дашчойлон” хийд рүү зүглээд л бөөн түгжрэл. Замын хоёр талаар нь машин тавьчихна. Өргөтгөж, шинэчилсэн юм байхгүй. Хойшоо 16 руу ч ялгаагүй. Дээрээс нь Баянбүрдийн тойргоос наашлаад 100 айлын уулзвар хүртэл км гаруйхан газар таван гэрлэн дохио байрлаж байгаа. Гуравдугаар сургуулийн цаад уулзвараас “Авто плаза”-гийн шинэ уулзвар хүртэл гурван гэрлэн дохио ойрхон ойрхон байх жишээтэй. Машинтай 10, 20 метр явж чадаагүй байтал л гэрлэн дохион нь асчихна. Тэгээд л зогсоод байна даа. Шинэ уулзвар нээгдсэнээс хойш бүр илүү түгжирдэг болсон гэсэн үг. Юун түгжрэл буурах манатай. Ядаж гуравдугаар сургуулийн өмнөх гэрлэн дохиогоо аваад хаячих хэрэгтэй шүү дээ. Сургуулийн орчим, хүүхдэд аюулгүй байлгах гэж хийж байгаа байх л дээ. Гэвч түгжрэлд улам л нэрмээс болоод байна.

Түүний оронд хурд сааруулагч хийчихвэл арай дээр байх. Одоо ямар нэгэнт хийчихсэн уулзварыг буцаагаад хаалтай биш. Өдөр болгон энэ замаар зөрчиж байгаа хүний хувьд аргаа бараад үгээ хэллээ. Ер нь сүүлийн үед замын түгжрэлийг бууруулахтай холбоотой шийдвэрүүд жаахан нүдээ олохгүй л байна уу даа. Тэр судалгаа, шинжилгээг нь ямар ч хүмүүс хийгээд байгаа юм. Түгжрэл буурах биш нэмэх ажил ч хийгээд байх шиг. Цаашид энэ мэт уулзвар барьж, түгжрэл бууруулахаар шийдвэл сайтар судалмаар юмаа. Хоёр км хүрэхгүй замд ийм олон уулзвар байж болдог ч юм уу, үгүй ч юм уу. Бас л бодох л асуудал байсан. Мэргэжилтнүүд нь асуудлаа мэдэж байгаа байлгүй дээ. Гэхдээ л түгжрэл яах аргагүй нэмэгдчихээд байна, 100 айл хавьд.

## УЛС ТӨР



# ШУВТАРСАН ЦАГААН БУМБАНДАА

Х.БҮРЭНТОГТОХ

**1.**

Улс орны эгзэгтэй үед засгаа тогтвортой байлгасан нь хождог. Олсон амжилтаа манах, болзошгүй аюулаас сэрэмжлэх гэдэг энэ бөлгөө. Ч. Лодойдамба зохиолчийн “Хугараагүй ноён нуруу” гэж өгүүлэг бий. Тэнд: “Зовж явахад тэвчээр, Жаргаж явахад сэрэмж” гэж үг бий. Ямар ч зовлон бэрхшээлийн өмнө сөхрөхгүй байх бол хамгийн том эр зориг юм. Өнөөдрийн хүлээцгүй болсон ертөнцөд сэлэм эргүүлж, сэнс шиг эргэсэн нь эр зоригтон биш болоод байна, цаана чинь. Тэвчээр гаргана гэдэг том эр зориг болчихоод байна. Энийг манайд ч биш дайн дажин, хямрал дефолт болж буй газар бүр ойлгож эхэллээ. Амгалан амьдрал шиг үнэн энэ дэлхий дээр байхгүй болжээ гэдэгт бүгд санал нийлж байна. Үүн лугаа адил тэвчээр хатуужил бол эр зоригийн дээд хэлбэр болж байна.

Аливаад хүлээцтэй хандах ч эр зоригийн дээд хэлбэр болж байна. “Конус” эргэж чаддаг нь биш консенсус хийж чаддаг хүн эр зоригтон болчихоод байна. Черчилль гуай дөрвөн жилд солигдож байдаг Ерөнхий сайдтай ИБУИВУ-ын Ерөнхий сайдыг 9 жил хийвээ гэвэл ард түмний хүсэл тийм байж. Энгийн ард түмэн хүнд хэцүү үедээ төрөө тогтвортой байхыг хичээдэг. Г.Коль гуай 16 жил канцлер хийвээ гэвэл хёор Герман нэгдсэн, Дэлхийн байдал өөрчлөгдсөн эгзэгтэй үе л байсан байхгүй юу.Рузвельт 1933-1945 онд АНУ-ын Ерөнхийлөгч байсан. Энэ бол Дэлхий дахинаа дайн байлдаан болж байсан эгзэгтэй үе. Нэг бодлого, нэг төр гэж ойлголт байна.

Манайх хямралтай үед иим л баймаар. Гэвч хүлээцгүй босон монголчууд ядаж хугацааных нь дөрвөн жилийг өнгөрөөвөл мөн хэрэгтэйсэн. Сингапурын Ли Куан Ю гуай 1959-1990 он гээд 31 жил байхдаа хөгжлийг хөлд нь оруулсан. Манайх нэгэнт Сингапур болох хүлээц, тэвчээр, эр зориг байхгүйгээс хойш ядаж дөрвөн жил байлгаж үзье. П.Жасрай, Н.Энхбаяр нараас өөр бүтэн дөрвөн жил байсан Засаг алга. 27 жилд Содном гуайг оруулаад давхардсан тоогоор бараг 20-иод Ерөнхий сайдын нүүр үзэх нь. Нэг нь гарч ирээд урдахь юмаа орвонгоор нь өөрчилдөг. Мэргэжилтнээс жижүүр, жолооч, бичээч бүгд хөдлөнө. Гэтэл Япон засгаа олон сольдог ч урд талын явуулсан бодлогын 10 хүрэхгүй хувьд л өөрчлөлт оруулдаг гэсэн дүгнэлт гарч. Тэнд ёстой хэн Ерөнхий сайд байх нь хамаагүй Япон бодлого ёс шиг хэрэгжинэ. Манайд ингэж чадахгүйгээс хойш нэгнээ тэвчээртэй, хүлээцтэй харж суръя даа, ядаж. Энгийн ардын логик иим байна.

**2.**

“Бусдад муу л байвал надад сайн гэдэг зарчим”-д бид их дасчээ. Энэ бол хоцрогдсон ойлголт. Сөрөг хүчнээ сөнөөж л байвал болно гэж. Гэтэл манайд хоёр том нам гол төлөв эрх барьдаг. Энэ хоёр улс төрийн хүчний бодлогын цаана угтаа Монгол улсын эрх ашиг явдаг.




Нэг иим зураг твиттерт яваад байгаа юм. Үнэхээр энэ Засгийн газар хасах руугаа орсон эдийн засгийн уналтыг 5.3 хувиар өсөлт рүү нь оруулжээ. Энэ бол аз нь байна уу, ажил нь байна уу, гавьяа юм. Хасахаас нэмэх болоод тэгээд 5.3 болно гэдэг нийт утгаараа 6-7 хувийн өсөлт юм. Ач холбогдлоороо 10 хувийн өсөлттэй тэнцэх эд л дээ, уг нь. Жиргээч Ganchimeg.N @Ganchimeg_n Р. Амаржаргалын энэ хэлсэн үгийн зүйлт тайлбартаа : “Гэсэн байх юм. Гэснээс засаг огцрох үндэслэл чинь яг юу билээ? Талцал билүү?” гэжээ. Энэ бол энгийн ард зон бидний энгийн логик гаргалгаа. Энгийн бид бол Засаг эдийн засгаа аварч явахад тэр засаг оршин тогтнож байх ёстой л гэж ойлгодог. Энгийн логик бол хамгийн эрэлттэй логик юм байгаа юм ч тээ, уг нь. Манай дарга, улс төрчид өөрсдийнхөө логикийг тулгадагаас биш.

> ...Ерөнхий сайд болдог Дэлхийн жишиг байдаг юм аа” гээд Дэлхийн жишгээр явахаар бужигнуулав. Мэдээж нэмэлт хачир элдэв шалтаг шалтгаан байлгүй яахав. Тэр шалтгаан дотор: “Энхсайхан өөрийнхөө, бусдын үгийг авдаггүй” гэдэг хүртэл шалтгаан тууж явав. Ерөнхий сайд өөрийнхөөрөө өөрийн толгойтой байхаас хэнийхээр байх ёстой юм бүү мэд. За ингээд арай ахиу суудалтай намын дарга Ц.Элбэгдорж Засгаа тэргүүлэх боллоо. Ингээд Дэлхийн жишигт орсон юм чинь “дэлбэлээд” өгөх нь дээ гээд баясцгаав. Бас байдаггүй...

Ноён Р.Амаржаргал бол хамгийн голтой улс төрч хүн. Засаг унагахын горыг мэддэг нэгэн.

“Бусдад муу л байвал надад сайн гэдэг зарчим”-ын муу тал нь эцсийн дүндээ ялсан ялагдсан аль аль тал нь хохирдог. Хамгийн том хохирогч нь ард түмэн бид болдог. Энгийн логикийн эзэд болдог. Улс төрийн ашиг хонжоо хайгчид хожлоо гэж бодовч эцсийн дүндээ бас л хожигдсон байдаг. 1996-2000 онд Ардчилсан холбоoo эвсэл анх төр засгаа төвхнүүллээ. М.Энхсайханы Засгийн газар юм хийх гэж их л идэвхтэй байлаа. П.Жасрай гуайн Засгийн газар Монгол орныг картын бараанаас дөнгөж салгасан үе. Эдийн засгаа сэхээх эхлэл тавиад, гадаад худалдаагаа эерэг үзүүлэлттэй болгоод байсан. Ёстой өвгөн Ерөнхий сайд: “Хонгилын үзүүрт гэрэл гарлаа” гэж өөрөө оножхэлсэн юм. Тэрийг нь тэр үед төрхгүй залуучууд онигоо шахуу болгож гуйвуулж байлаа. За ингээд П.Жасрай гуайн нам ялагдснаар М.Энхсайхан Засгаа төвхнүүллээ. Нэг жил найман сар нилээн юм хийх гэж оролдлоо. Хүмүүсийн ам ч гайгүй байлаа. Гэтэл “Ялсан намын дарга нь Ерөнхий сайд болдог Дэлхийн жишиг байдаг юм аа” гээд Дэлхийн жишгээр явахаар бужигнуулав. Мэдээж нэмэлт хачир элдэв шалтаг шалтгаан байлгүй яахав. Тэр шалтгаан дотор: “Энхсайхан өөрийнхөө, бусдын үгийг авдаггүй” гэдэг хүртэл шалтгаан тууж явав. Ерөнхий сайд өөрийнхөөрөө өөрийн толгойтой байхаас хэнийхээр байх ёстой юм бүү мэд. За ингээд арай ахиу суудалтай намын дарга Ц.Элбэгдорж Засгаа тэргүүлэх боллоо. Ингээд Дэлхийн жишигт орсон юм чинь “дэлбэлээд” өгөх нь дээ гээд баясцгаав. Бас байдаггүй. Шувтарсан цагаан бумбандаа гэгч л болов. Тэгснээ гурван сар болоод огцордог ч бил үү, зургаан сар үүрэг гүйцэтгэгч хийдэг ч бил үү юм боллоо. Уг нь хойд хөршид С.Кириенко гээд 34 настай залуу Ерөнхий сайд боллоо. Манайд арай илүү 33 настай Элбэгдорж боллоо гээд пиардлаа. Бүс нутгийн жишиг болтол нь пиардаж гарлаа. Гэтэл Кириенко бас дөрвөн сар болоод “шувтарсан цагаан бумбандаа” гэгч болов оо. Кириенко 1998 оны 4-8 дугаар сард ОХУ-ын Ерөнхий сайд байв. За ингээд Ж.Наранцацралт хотын даргын албанаас 1999 оны төгсгөлд Ерөнхий сайдын албанд очив. Гэтэл Эрдэнэт үйлдвэрийн оросын талын 49 хувийг хоёр “Белаз”-ын дугуйгаар зарах гэлээ. Тийм бичиг олдлоо гээд л шуугив. Бас л 2000 оны наадмын дараа шувтарлаа. Гэтэл тэр 49 хувийг Оросууд 2016 онд л нэг тийш нь болголоо л доо. Оросын хувийн төлөө бид санаа зовох ч хаашаа юм. Тэгээд хоёр Белазын дугуй ч гэж хаашаа юм. Энгийн логик: “Яаж байгаа юм бол доо?” гэж асуухаар: “Итали, Японд ингэж Засгийн газраа унагаадаг Дэлхийн жишиг байдаг юм аа. 20 хоноод унасан Засгийн газар ч байна” л гэсэн. Энгийн логик: “Засгийн газраа унагаад байвал Япон, Итали шиг л болох нь дээ” гэж эргэлзэнгүй атлаа итгэж таарна даа. Инээдэм, ханиадам. Ингээд Р.Амаржаргал 10 сар орчим Ерөнхий сайд болж байж гэмээ нь эстафетаа Н.Энхбаярт өгсөн дөө. Түүний гор нь УИХ-д ганц суудал авсан нь Ж.Наранцацралт байлаа. Өнөө Дэлхийн жишгийн нам маань парламентийн гадуурх нам болох дөхөв. Энэ үед Засаг унагах талдаа 25 суудалтай Ардын нам (тухайн үеийн МАХН), түүний удирдагч Н. Энхбаяр гарамгай тоглож байв. МУНН-аас нэг гишүүн байсан О.Дашбалбар байлаа. О.Дашбалбар зохиолч Н.Энхбаяртай адил Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургууль төгссөн. Бас хамтдаа Монголын зохиолчдын хороонд ажилж байсан, үе тэнгийн үхэр хонин жилтэй найз нөхөд байв. 2000 онд “Ардчилсан холбоо эвсэл” арай чүү гэж дөрвөн Засгийн нүүр үзэж Их хуралд хохь ганц суудалтай үлдсэн түүх саяхных.

Бас шинэ баян цээж өвчтэй гэж 2000 оны сонгуульд энэ эвсэл задарч сонгуульд ороод, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, дөрвөн Засагт сайд хийсэн 40-өөд хүн цөм шувтарсан цагаан бумбандаа болов. Иим зовлонг бие сэтгэлээрээ мэддэг учраас Р.Амаржаргал иим үг хэлээд байгаа юм. Тэр тогтвортой байдлыг л хүсэж байгаа түүнээс МАН-д хайртай даа биш. Ж.Эрдэнэбатад хайртайдаа бүр ч биш. Улс орон овоо ололтоо манаж чадахгүй нь гэж л айж, болгоомжилж байгаа. Тэр намын эрх ашгийн төлөө УИХ-ын суудлаас татгалзаж чаддаг хүн. Улс эх орны эрх ашгийн төлөө

“Бусдад муу л байвал надад сайн гэдэг зарчим”-аас татгалзаж чадаж байна даа. Дээрх дөрвөн засаг гарч ирэх болгондоо бүгдээрээ мандуулна гэж байсан юм шүү гэдгийг онцлон тэмдэглэхэд таатай байна. Яг өнөөгийн амбицитай улс шиг. “Хаа байсан билээ. Гэнэтхэн цооров уу? Энэ чинь” гэмээр л мэдэгдэл хийдэг юм. Энэ бол шинэ бүжиг биш хуучин “танец”. Одоо арай нийгэм хөгжөөд: “Энхсайхан өөрийнхөөрөө байдаг” гэсэн шалтгаан хэлэхгүй байна. Энгийн логик ч хөгжөөд ирсэн. Жишээ нь, 60 тэрбум гэдэг нэг шалтгаан. Доржзодов гэдэг хүн стартегич мэргэжилтэй хүн. Намын сонгуулийн мөнгө босгох арга зааж өгөөд түүнийг нь сонсож яриа дэлгэсэн төлөө хаа байгаа Засаг унах нь мөн үү. Эрх зүйт төрийг цогцлон бүтээж байгаа логикууд бид логикоороо баймаар. Хууль зөрчсөн үү, үгүй юу гэдгийг хууль шийднэ. Хуульд харшлах юмгүй бол нам нь дотооддоо шийднэ. Үйлдэл нь хаа байгаа юм бэ? Үйлдэлгүй үйлдлээр хүмүүсийг хохироож болох уу? Одоо тэгээд мөнгө богоё гэсэн уран арга зааж өгье гэсэн үг сонслоо гээд Засгийн газраа солих гээд байгаа юм уу? Хүний үг сонсож, түүнээ бичүүлж болохоо байсан цаг уу? Гэм буруу нь тогтоогүй бол гэм буруутан биш гэж үг байна. Нотлох баримтыг зөвхөн Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа яуулах эрх бүхий этгээд гаргасныг тооцно гээд зарчим байна. Ахуйн нөхцөлд дэмий чалчих чинь хуульд ямар падлий байна. Хурал цуглаан, бодлого шийдвэр болгосон биш. Намдаа мөнгө өгөөгүй, сонгуульд мөнгө зараагүй нэг ч дарга сайд, гишүүн байгаа юм уу. Одоо энийг нэг мөр цэгцлэхээ бодох цаг. 37 он буцаад ирсэн үү? Улсын цирк ч гэл үү, театр ч гэл үү шатаж байхад: “Гүй ээ мөн зүмбэрлээд сайхан шатаж байна аа” гэж хэлээд 10 жил авсан юм гэнэ лээ. Сонгуулийн өмнө мөнгө эрж байгаа намын нөхөр нэг нөхрийн яриаг сонссо л биз.

Тэр ярьсан сэдсэн хүмүүс бичлэгээ тараагаа л биз? Хүн хөгжжө өдөөчихөөд өөтэй ганц хоёр үг сонсоод түүнээ бичлэг болгон тараагаад Улсын баатар болдог бол амархан юм байна. Тэр Гонгор, Дандар баатрууд Улсын баатар, дарга Бат-Үүл эн тэр ингэж баатар болоогүй байлгүй. Хуулийн юмыг хуулиараа, намын юмыг намаараа. Бүхнийг самардаад байвал бүтэхгүй.

**3.**

2012-2016 онд шинэчлэлийн, шийдлийн Засгийн газар гээд хоёр Засаг дамжиж 20 сайд сольж хутгаж байгаад эстафета өгсөн байх. Бас л баахан бужигнаан. Шинэчлэл ч үгүй шийдэл ч үгүй, шидлийн өртэй л үлдээсэн гэсэн дүр зураг гараад байгаа юм даа. За тэгээд юу гэхэв, МАН нь АН-аараа тоглодог байсан бол одоо АН нь МАН-аараа тоглодог болох нь дээ. “Цаг цагаараа байдагүй цахилдаг хөхөөрөө байдагүй” гэдэг энэ болой. Харин АН-ын дарга С.Эрдэнэ: “Аль нэг Засгийн газрыг огцруулах нь АН-ын гол зорилго биш” гэж хэлсэн байгаа юм. Цугаараа шувтарсан цагаан бумбандаа гээгүй л байна. Уг нь болохгүйгээ янзалъя, болохоо хамжья, бултаара хийе гэж бид сурмаар юм. За энэ ч яахав, бид Сингапур болох зорилго байх биш дээ, гэвэл ч .......гэе.

MNB
MONGOLIAN NATIONAL BROADCASTER

**Нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалтад урьж байна.**

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ОРЧУУЛАГЧ РЕДАКТОР СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА**

**Ажлын байрны зорилго:**

Монгол Улсын гадаад, дотоод бодлого, улс төр, эдийн засаг, монголчуудын аж амьдрал, ахуй соёл, түүх уламжлал, ёс заншилын чиглэлээр нэвтрүүлэг сурвалжлага бэлтгэн орчуулж, хөтөлж гадаадын сонсогчдод хүргэнэ.

**Ажлын байранд тавигдах шаардлага:**
- Англи хэлний орчуулагч мэргэжлээр төгссөн / бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй/
- Англи хэлний бичгийн болон ярианы өндөр чадвар
- Эфирт нэвтрүүлэг хөтлөх чадвартай байх
- Уран бүтээлч сэтгэлгээтэй
- Сэтгүүл зүйн чиглэлээр их, дээд сургууль төгссөн бол давуу тал болно.
- Багаар ажиллаж, ачаалал даах чадвартай, харилцааны соёлтой
- Ажлын болон хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлага хүлээх чадвартай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй

**Бүрдүүлэх материал:**
- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын “Бусад” гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

*Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.*

**Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3
